## БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 01 дугаар сарын 05-ны өдөр

Баян-Өндөр сум

| д/д | д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | биелэлт | Хүрсэн үр дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | |
| 1 | 1 | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг салбарын хэмжээнд болон байгууллагын ажилтан албан хаагчдад сурталчлах; | Тайлант онд байгууллагын www.orkhon.sport.gov.mn болон сошиал сүлжээнд “Орхон БТСГ”-ын профайл зургаар болон ажилтан албан хаагчдын “БТСГ ажилчид” хуудсуудад авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн гарын авлага 1, шторк 2, пост 4 тус тус байршуулж, иргэд олон нийт, ажилтан албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар сурталчилсан. | Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт өгч, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлсэн. | 100% |
| 2 | 2 | 1.2.Авлигын эсрэг нөлөөллийн 2-оос доошгүй үйл ажиллагааг зохион байгуулах; | | | |
| 3 | 3 | 1.3. Байгуулагын А заал болон Уурхайчин зааланд авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс хөгжил дэвшил”-д 110 мэдээллийн самбарыг шинээр хийж байрлуулах; | А зааланд хууль тогтоомжийн мэдээллийн самбар шинээр хийж “Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах” булан байршуулсан. Үүнд: авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, авлигыг үл тэвчих сурталчилгааны материал харуулах хэсэг, санал хүсэлт авах хайрцаг зэргийг тус тус байрлуулсан. | Иргэд, үйлчлүүлэгчдэд авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилж эхэлсэн. | 100% |
| 4 | 4 | 1.4. Байгуулагын А заал болон Уурхайчин зааланд авлига ашиг сонирхлын зөрчлийн талаарх санал, хүсэлт, өргөдөл, гомдол | А зааланд “Шударга ёс хөгжил дэвшил”-д 110 лого бүхий санал хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авах хайрцаг байрлуулсан. | Иргэдээс авлига ашиг сонирхлын зөрчлийн талаарх санал хүсэлт | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүлээн авах хайрцаг хийж байрлуулах | | өргөдөл гомдол хүлээн авах боломж бүрдсэн. | |
| 5 | 5 | 1.5.Авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий контент бэлтгэж, хэвлэл мэдээллийн болон сошиал сувагаар сурталчилж салбарын хэмжээнд манлайлах; | Тайлант онд байгууллагын www.orkhon.sport.gov.mn болон сошиал сүлжээнд “Орхон БТСГ”, ажилтан албан хаагчдын “БТСГ-н ажилчид” зэрэг хуудсуудад авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн гарын авлага 1, шторк 2, пост каст 2 тус тус байршуулж, иргэд олон нийт, ажилтан албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах талаар сурталчилсан. | Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт өгч, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлсэн. | |
| 2.Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | | | | | |
| 6 | 1 | Байгууллагад шинээр орсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулах; | Үйлчлэгч албан тушаалын сул орон тооны зарыг https://ejob.gov.mn/ сайт мөн байгууллагын сайтад байршуулж 2 удаагийн зар, мэдээллээр 2 ажилтанг шалгаруулж авсан. Гэр бүлийн ордоноос зохион байгуулсан ажилд анх орсон албан хаагчдад ажлын байрны менторшип чиглүүлэх сургалтад 3 албан хаагчийг 09 дүгээр сард хамруулсан. | Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах мэдлэг мэдээлэл олгосон. | 100% |
| 7 | 2 | Албан хаагчдад авлигын эсрэг сургалтад давтан болон ёс зүйн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах; | Ажилтан албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг сурталчилж зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлсэн. Удирдлагын академиас зохион байгуулсан 7-4-10 2 удаагийн, аймгийн ХЭЗХ-ээс 1 удаагийн зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, анхаарах болон 2022 оны ХАСХОМ шинэчлэн гаргах сургалтад нийт 4 албан хаагч, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн танилцуулга, Ёс зүйн сургалтад нийт 4 албан | Ажилтан албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлсэн. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хаагчийг танхим, цахим хэлбэрээр хамруулж, мэдээллийг хамт олны шуурхайн хуралд албан хаагчдад тухай бүр танилцуулан ажилласан. | | |
| 8 | 3 | Хамтран ажилладаг спортын холбоод, клубуудын удирдлагуудад төсвийн ил тод байдал, авлигаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа ажлыг зохион байгуулах; | Тайлант онд хамтран ажилладаг 18 спортын холбоо, клубуудын удирдлагуудад биеийн тамир спортын ажил үйлчилгээг явуулахад бодлого чиглэл, хамтран ажиллах эрх, үүрэг, гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлт, хариуцлагын талаар мэдээлэл өгөх хурлыг зохион байгуулсан. | Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар мэдээлэл хүргэсэн. | 100% |
| 9 | 4 | А заал болон Уурхайчин зааланд сонгон секц дугуйлангийн багш нарт авлигаас урьдчилан сэргийлэх, ёс зүйтэй тамирчин бэлтгэх талаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах; | Тус байгууллагын эзэмшил А заал болон Уурхайчин зааланд хичээллэдэг сонгон секц дугуйлангийн багш нар хүүхдүүдэд ёс зүйтэй байх талаар зөвлөмж зөвлөгөө өгч, бэлтгэл сургуулилт эхлэхийн өмнө өглөө бүр “Монгол Улсын Төрийн дуулал” дуулж, зааландаа хүндэтгэл үзүүлдэг болсон. | Тамирчдад багаас нь ёс зүйтэй байх ухамсар соёлыг бий болгож байна. | 100% |
| 3.Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | |
| 10 | 1 | 3.1.Биеийн тамир, спортын тэмцээн, уралдаан, өдөрлөгийн арга хэмжээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэл баримталж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах талаар хамтран ажиллах гэрээнд тусган хэрэгжүүлэх; | Тайлант онд тэмцээн, уралдаан зохион байгуулахдаа биеийн тамир, спортын 26 төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. Спортын холбоогүй байгууллагын тэмцээн, уралдааныг зохион байгуулахдаа тухайн тэмцээнийг хариуцан санхүүжилтийг хариуцан ажиллах холбоотой гэрээ байгуулан ажилласан. | Гэрээгээр ажиллах талууд авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахаар тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. | 90% |
| 11 | 2 | 3.2. “А заал” болон “Уурхайчин” зааланд чөлөөт тоглолт хийх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хийх гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх | Тайлант онд “А заал” болон “Уурхайчин” зааланд чөлөөт тоглолт хийх 11 аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулж, гэрээ дүгнэх тооцоо нийлсэн акт үйлдэн төлбөр тооцоог байгууллагын дансаар шилжүүлэн авч ажиллалаа. | Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийж, сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | талаар нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэх; | | | |
| 12 | 3 | 3.3.“А заал” болон “Уурхайчин” зааланд сонгон секц дугуйлан хичээллүүлэх багш нартай байгуулах спорт заалны түрээсийн гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх талаар нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэх; | Тайлант онд сонгон секц дугуйлан хичээллүүлэх 13 багш дасгалжуулагчтай заал ашиглалтын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж төлбөр тооцоог дансаар авч ажилласан. | Бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийж, сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж ажилласан. | 100% |
| 13 | 4 | 3.4.Авлига, ашиг сонирхлын холбогдолтой өргөдөл гомдлыг хүлээн авах хайрцагийг байнга ажиллуулах; | Байгууллагын А зааланд зааланд байрлуулсан “Шударга ёс хөгжил дэвшил”-д хайрцагаар санал хүсэлт, өргөдөл гомдол ирээгүй. | Иргэд, үйлчлүүлэгчдээс гаргасан санал хүсэлт, өргөдөл гомдол гаргах боломж нөхцлийг бүрдүүлсэн. | 100% |
| 4.Авлигын эрсдлийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээ авч ажиллах | | | | | |
| 14 | 1 | Спорт заал, барилга байгууламжийг түрээслүүлж орлого олох бүхий л төрлийн хүсэлтийг шийдвэрлэх үйл явцыг журмаар зохицуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах; | Тайлант онд Уурхайчин, А заал болон Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн гадна талбай, павилоныг түрээслэн нэмэлт санхүүжилтийн 100210035009, 100210035401 тоот дансанд төвлөрүүлсэн. Нэмэлт орлого төвлөрүүлэхдээ QR код ашиглан бэлэн мөнгөтэй харилцахгүй иргэд, аж ахуй нэгжид чирэгдэлгүй хурдан шуурхай арга хэмжээ авч ажилласан. | Байгууллагын ажилтан албан хаагчид бэлэн мөнгөтэй харилцахгүйгээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлсэн. | 100% |
| 15 | 2 | Биеийн тамир, спортын ажил үйлчилгээг спортын чиглэлийн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах талаар уулзалт зохион байгуулж, гаргасан санал | Биеийн тамир, спортын ажил үйлчилгээг 2022 онд биеийн тамир, спортын 26 төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн. Тайлант онд 18 спортын холбоо, клубуудын удирдлага, нарийн бичгийн дарга нартай “Уурхайчин” заалны хурлын танхимд | Биеийн тамир, спортын газраас 2022 онд спортын холбоо клубуудтэй хамтран ажиллах талаар 2 ахлах мэргэжилтэн хариуцан ажиллаж байсан бол 2023 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх; | уулзалт зохион байгуулж, биеийн тамир спортын газраас спорт холбоодыг хариуцан ажиллах албан хаагчдын хуваарилалт, гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, спортын өндөр амжилт гаргасан тамирчдын урамшууллыг нэмэгдүүлэх талаар харилцан санал солилцсон. Тус газраас биеийн тамир, спортын ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмын төслийг боловсруулж, захиргааны ерөнхий хуульд заасны дагуу спорт холбоо, клубуудээс санал авсан. Биеийн тамир, спортын газрын даргын 2023 оны А/84 дүгээр тушаалаар "биеийн тамир спортын ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх журам"-г баталж, спортын холбоо клубуудэд хүргүүлсэн. | оноос албан хаагчдыг чиг үүргийн дагуу спортын холбоо клубуудэд хуваарилж, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлсэн үр дүнтэй ажил болсон. | |
| 16 | 3 | Үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллага спорт холбоодоос сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагааг сайжруулж ажиллах | Тайлант онд гэрээ байгуулсан багш дасгалжуулагч, аж ахуйн нэгж, байгууллагуудаас 5 удаа санал хүсэлт гаргасныг тухай бүр нь шийдвэрлэж гэрээнд заасан үүргээ биелүүлж ажилласан. | Үйл ажиллагаанд алдаа дутагдал гаргахгүй ажилласан. | 100% |
| 17 | 4 | Шинээр томилогдсон болон ажиллаж байгаа нийтийн албан тушаалтан хуульд заасан хугацааны дотор хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргах; | Тус байгууллагад төрийн захиргааны удирдах албан тушаалтан 3 ажилладаг. Эдгээр 3 албан тушаалтан 2023 онд хөрөнгө орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд мэдүүлж ажилласан. | Хуульд заасан хугацааны дотор хөрөнгө орлогоо мэдүүлсэн. | 100% |
| 18 | 5 | Ажилтан албан хаагчдын ажил, албан тушаалын тодорхойлолтод ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, ашиг сонирхлын зөрчилтөй гэж ойлгогдохуйц | Гэрээт 4 харуулын ажил, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн хугацаатай гэрээг шинэчлэн боловсруулж, гэрээг байгуулсан. | Газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/142 дугаар тушаалаар ажил,албан тушаалын тодорхойлолтыг баталсан. | 50% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нөхцөл байдал бий болсон бол мэдэгдэл, тайлбарыг гаргуулж байх талаар нэмэлт өөрчлөлт тусгах; | | 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хөдөлмөрийн хугацаатай гэрээг даргатай байгуулсан. | |
| 5.Байгууллагын удирдах албан хаагчдын авилгатай тэмцэх хүсэл | | | | | |
| 19 | 1 | Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, тайланг www.orkhon.sport.gov оруулж үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг бүх албан хаагчдад тайлагнах; | Тус газрын дарга авлигын эсрэг ажиллах 2023 оны төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж байгууллагын www.orkhon.sport.gov.mn сайтад байршуулж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна. | Хууль тогтоомжийг биелүүлж, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлсэн. | 100% |
| 20 | 2 | Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах талаар судлах; | Тайлант онд засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан “Монголын хүүхдийн спортын зуны болон өвлийн VII наадам”, “Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам”-д Орхон аймгаас оролцсон нийт 320 тамичны мэдүүлэг бүртгэлийг цахимаар хүргүүлж ажилласан. | Үйлчилгээг түргэн шуурхай болгож, хүнд сурталгүй ажилласан. | 100% |
| 6.Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах | | | | | |
| 21 | 1 | Байгууллагын www.orkhon.sport.gov.mn сайтад үйл ажиллагааны мэдээ мэдээллийг байнга оруулж, ил тод нээлттэй байдлыг хангаж ажиллах; | Байгууллагын www.orkhon.sport.gov.mn сайт сошиал сүлжээнд “Орхон БТСГ” групп, “Орхон аймгийн Биеийн тамир, спортын газар” пэйж хуудсуудад үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тогтмол оруулж, ил тод нээлттэй байдлыг хангаж ажилласан. | Мэдээ мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. | 100% |
| 22 | 2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж | Биеийн тамир, спортын газрын даргын 2022 оны 07 сарын 05-ны өдрийн “Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй мэдээллийг цахим | Мэдээ мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын цахим хуудсанд мэдээллийг шинэчилж байх ажилтнуудыг тушаалаар томилж, үүрэгжүүлж ажиллах; | хуудсанд байршуулах хуваарь батлах тухай" А/91 дүгээр тушаалаар байгууллагын www.orkhon.sport.gov.mn сайтад мэдээллийг шинэчилж байх ажилтныг томилсон. Тушаалын дагуу 40 мэдээллийг цахим хуудсанд шинэчлэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллалаа. | | |
| 23 | 3 | Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуулийн хугацаанд нь цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулах; | Тайлант онд 159 мэдээллийг https://info.shilendans.gov.mn сайтад 28 талбарт оруулахаас 158 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан. байна. | Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажилласан. | 99,3% |
| 24 | 4 | Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлт, төсвийн хэтрэлт, түүний шалтгаан тайлбар; | Тайлант онд https://info.shilendans.gov.mn сайтад 12 талбарт хугацаа хоцролгүй тайлагнасан. | Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 25 | 5 | Байгууллагын төлбөр хураамжид орсон өөрчлөлт, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, хаяг; | Тайлант онд https://info.shilendans.gov.mn сайтад 12 талбарт хугацаа хоцролгүй тайлагнасан. | Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 26 | 6 | Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Тайлант онд https://info.shilendans.gov.mn сайтад 12 талбарт хугацаа хоцролгүй тайлагнасан. | Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж ажилласан. | 100% |
| 7.Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, гүйцэтгүүлэхдээ авилга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 27 | 1 | Байгууллагын үйл ажиллагаанд бараа, ажил үйлчилгээ худалдан авахад харьцуулалтын аргыг хэрэглэж хэвших; | Тайлант онд бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын үнийн арга ашигласан. | Сонирхлын зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлсэн. | 100% |
| 28 | 2 | Байгууллагад хууль тогтоомжийн дагуу олж буй бүх төрлийн орлогыг QPAY уншуулж, соёлтой үйлчилгээ үзүүлэх; | Qpay-р орлого төвлөрүүлэх гүйлгээ хийгддэг бөгөөд тайлант онд 53,0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж ажилласан. | Шан харамж авах, сонирхлын зөрчил үүсгэхээс урьдчилан сэргийлсэн. | 100% |
| 8.Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдэгдэл, зөвлөмж, шийдвэрийг биелүүлж, тайлагнах | | | | | |
| 29 | 1 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлж авилга ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах; | Тайлант онд Улсын Их Хурлын 2023 оны 06 сарын 30-ны өдөр батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг байгууллагын ажилтан, албан хаагчдад танилцуулсан. 2023 онд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 29 арга хэмжээ хэрэгжүүлж ажиллахаас 26 арга хэмжээг 100%, 1 арга хэмжээ 99,3%, 1 арга хэмжээг 50%, 1 арга хэмжээг хойшлуулсан 0%, 94,7%-иар биелэлтийг хангаж ажилласан. | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж зөрчлөөс урьдчилан сэргийлж ажилласан. | 100% |
| Төлөвлөгөөний биелэлт-98,8% | | | | | |

ХЯНАСАН:
ДАРГА Д.ДЭЛГЭРБАЯР
ТАЙЛАН ГАРГАСАН:
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ХҮНИЙ НӨӨЦИЙН
АЖИЛТАН Ч.БОЛДЦЭЦЭГ

ТТО... 9041893